



ЕРӨӨ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020 07 30 № 007-2020/04-НА-05  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ерөө сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ерөө сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020560


## Дүгнэлт

Ерөө сумын Монгол Ардын намын хорооны Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ерөө сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...6... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Ерөө сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**МОНГОЛ АРДЫН НАМ**


**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**2020 он**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2020.06.25

Тавин

**УРИАЛГА : ИРГЭНЭЭ ДЭМЖЬЕ, ХАМТДАА ХӨГЖЬЕ.**

**Нэг. НИЙГМИЙН БОДЛОГО: ЭРҮҮЛ ХҮН-ХӨГЖЛИЙН ҮНДЭС**

**1.1 Боловсролын хүрээнд**

- 1.1.1 СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхэд багачуудыг эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Ерөө суманд шинээр баригдах 200 ортой цэцэрлэгийг ашиглалтад оруулах, урсгал зардал болон орон тооны асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 1.1.2 Ерөө суманд 960 хүүхдийн суудал бүхий олон улсын стандартад нийцсэн сургуулийн барилгыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулна.
- 1.1.3 Хүн амын төвлөрөл, шилжилт хөдөлгөөн, сургуулийн насны хүүхдийн тоо, эрэлт, хэрэгцээнд тулгуурлан 150 хүүхдийн дотуур байрны асуудлыг холбогдох байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.
- 1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллана.
- 1.1.5 Чадварлаг, мэргэжлийн боловсон хүчнийг түшиглэн төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай сургууль болох эх суурийг тавин, сургалтын орчныг бүрдүүлнэ.
- 1.1.6 Мэдээлэл харилцааны технологийг хөгжүүлж цахим сургалтын арга зүйг улам боловсронгуй болгон техник хэрэгслийг нэмэгдүүлэн шинэчлэх ажлыг хийнэ.
- 1.1.7 Төгсөх ангийн сурагчдын дунд “Мэргэжил сонголт” арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж мэргэжлээ сонгоход нь арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажлын байртай танилцах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.1.8 Насан туршийн боловсролын сургалтын орчныг сайжруулна.
- 1.1.9 Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлж гадаад болон дотоодод туршлага судлуулах ажлыг дэмжинэ.



- 1.1.10 “Багш, сурагч солилцоо” хөтөлбөр боловсруулан хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.11 Сумын төвөөс алслагдсан хэсгийн өрхийн хүүхдүүдийг зөөвөрлөх унааны асуудлыг сэргээн шийдвэрлэнэ.
- 1.1.12 Сонгон, дугуйлан, хөгжүүлэх клубүүдээр хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж амжилт гаргасан багш, ажилтан, суралцагчдыг дэмжин урамшуулна.
- 1.1.13 Сум, орон нутгийн хэмжээнд гэрээр хүмүүжиж буй бага насны хүүхэд багачуудыг Хүүхэд харах үйлчилгээнд хамруулж СӨБ-д хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлэн дэмжиж ажиллана.
- 1.1.14 Бугант тосгоны ЕБС, хуучин цэцэрлэгийн байрны их засварын ажлыг хийж гүйцэтгэх талаар холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 1.1.15 Боломжит төсөл, хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр сумандаа тодорхой мэргэжлийн МСҮТ-ийг шинээр байгуулж мэргэжилтэй залуу, боловсон хүчнийг бэлтгэх талаар анхаарч ажиллана.

## **1.2. Эрүүл мэндийн хүрээнд**

- 1.2.1 “Эрүүл хүүхэд Ерөөгийн ирээдүй” уриан дор хүүхэд багачуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.2 Ерөө, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх талаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.2.3 Иргэн бүрийг жилд 1 удаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.4 “Амны хөндийн эрүүл мэнд хөтөлбөр”-ийн хүрээнд шүдний эмчтэй болох асуудлыг холбогдох шатанд уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.2.5 Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.2.6 Хөдөөгийн өрх, малчдад жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж ажиллана.
- 1.2.7 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж, бүх нийтийн үйлс болгон зохион байгуулна.
- 1.2.8 Ахмадын сувиллын үйл ажиллагааг сэргээн тогтмолжуулж, бие эрүүл, сэтгэл амар, ая тухтай орчныг бүрдүүлнэ.
- 1.2.9 Сумын иргэдийн эрүүл зөв хооллолт, стресс бухимдлаас ангид байх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх, дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх “Эрүүл зөв амьдрал” төвийг нээн ажиллуулах талаар төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.



### 1.3.Спорт, соёл урлагийн хүрээнд

- 1.3.1 Сумандаа 500 хүний суудалтай шинэ Соёлын төв барих санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.3.2 Сумын номын сангийн уншлагын танхимыг интернэтэд холбож компьютер, тоног төхөөрөмжөөр ханган, номын фондыг нэмэгдүүлэн цахим номын сангийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.3.3 Соёлын төвийн үндэсний хөгжмийг шинэчилнэ. /Ёочин, шанз, ятга, морин хуур, хуучир, лимбэ гэх мэт/
- 1.3.4 Ахмадын өргөөний халаалтын асуудлыг шийдвэрлэж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 1.3.5 Сумын орон нутаг судлах музейн үзмэрийг баяжуулж, нутаг орныхоо онцлог, түүх соёлын онцлогийг сурталчилна.
- 1.3.6 Бугант тосгонд иргэд, хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих орчныг бүрдүүлэх зорилгоор спорт цогцолборыг байгуулах санхүүжилтийг улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.3.7 Сумандаа өвлийн спортыг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.
- 1.3.8 “Шинэ давлагаа Ерөөгийн хөгжилд” спортын наадмыг жил бүр зохион байгуулна.

### Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО: ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН ЕРӨӨЧҮҮД

- 2.1 Бугант тосгоныг сумын төвтэй хатуу хучилттай замаар холбох ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийн, улсын төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 2.2 Сумын төвийг “4 зам-Хүдэр” чиглэлийн хатуу хучилттай замтай холбох ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- 2.3 Ерөө сумын 1-р багийн Энхталын зарим малчин өрх, 2-р багийн Хужирынхаяа хэсгийн айл өрхүүдийг цахилгаан, эрчим хүчээр хангах ажлын санхүүжилтийг шийдвэрлэн, мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.
- 2.4 Ойн мэргэжлийн байгууллагуудыг түшиглэн мод боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн гаргах үйлдвэрийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.5 Шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгуулах санал хүргүүлж, гүйцэтгэнэ.
- 2.6 Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь замуудыг хатуу хучилттай болгох ажлыг аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.7 Шинэ суурьшлын бүсэд “Хаус” хороолол барьж, байгуулах санал санаачилгыг дэмжиж, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор эхлүүлнэ.
- 2.8 Гудамж талбайн гэрэлтүүлгийг засварлан, тодорхой хэсгүүдэд нэмж гэрэлтүүлэг тавих асуудлыг дэс дараатай хийж гүйцэтгэнэ.




- 2.9 Ерөө суманд худалдааны төвийг барьж, ашиглалтад оруулах санхүүжилтийг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.10 Инженерийн байгууламж, шугам сүлжээг байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагууд болон айл өрхүүдийг холбох ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хандаж, шийдвэрлүүлнэ.
- 2.11 Сумын төвийн урд жижиг гүүрнээс Гэрэлтхайлааст /тасаг/ хүртэлх замыг сайжруулан засварлана.
- 2.12 Бугант тосгоны 5 давхар байрнуудын дээврийг шинэчлэх, засварлах, хуучин захирагчийн албаны байрны их засварын ажлын санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлж, хийж гүйцэтгэнэ.
- 2.13 Сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн камержуулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.14 Сумын хэмжээн дэх тоглоомын талбайг стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомоор баяжуулан, хуучин талбайнуудыг засаж шинэчлэн, шинээр барьж, байгуулна.

**Гурав. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО: ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ: БИД ҮЙЛДВЭРЛЭГЧИД**

- 3.1 Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй болон зоорины аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 3.2 Ногоочдын хоршоо, холбооны үйл ажиллагааг эрчимжүүлж дэмжин, орон нутгийн иргэдийн тариалсан төмс, хүнсний ногоог дотоодын зах зээлд борлуулах ажлыг зохион байгуулна.
- 3.3 Хадлан, бэлчээрийн талбайг сайжруулж, олон наст ургамал тариалсан малчид, хоршоог бодлогоор дэмжинэ.
- 3.4 Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, "Эрүүл малтай" сум болно.
- 3.5 Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрт худаг ус гаргах, зам давааг засан сайжруулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.
- 3.6 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт мал аж ахуйтай хослуулан эрхлэхийг дэмжинэ.
- 3.7 Мод, жимс, жимсгэнийн тарьц суулгацаар сумын иргэдийг хангах талаар ААН, иргэдээс гаргасан санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 3.8 Өрхийн үйлдвэрлэлээр гэрийн мод, гэр ахуйн модон эдлэл үйлдвэрлэх иргэдэд үйлдвэрлэлийн хэрэгцээний мод бэлтгэх боломжоор хангана.
- 3.9 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн, журмын дагуу зарцуулж, хяналт, шалгалтыг сайжруулна.
- 3.10 Мал угаалгын ванныг хөдөөгийн хэсгүүдэд барьж байгуулна.



## **Дөрөв. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО: НОГООН СУМ-НОГООН ЕРӨӨ**



- 4.1 Сумандаа ой цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, ажил хайгч иргэдийг түр ажлын байраар хангахын зэрэгцээ ахмад настан болон зорилтот бүлгийн өрхийг түлшний модоор хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.2 Ерөө, Бугантын байгалийн үзэсгэлэнт газруудад аялал жуулчлалын бааз хотхоныг байгуулж дотоодын аялал, жуулчлалыг орон нутагт хөгжих боломжийг бүрдүүлж, санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.
- 4.3 Булаг шандын эхийг хамгаалах, ойжуулалтын арга хэмжээг нэмэгдүүлэх ажлыг төсөл, хөтөлбөрт хамруулах замаар хэрэгжүүлнэ.
- 4.4 Сумын нэгдсэн хогийн цэгийг хашаажуулж, байнгын харуул хамгаалалттай болгох, камержуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, улмаар нүүлгэн шилжүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч ажиллана.
- 4.5 "Ногоон Ерөө" хөтөлбөрийг боловсруулан өрх бүр ногоон байгууламж бий болгох замаар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 4.6 Бичил уурхай эрхлэгч, нөхөрлөлүүдээр уул уурхайн олборлолт явагдаж орхигдсон газруудыг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи ашиглан, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.7 Ерөө голыг цэвэр урсгах зорилгоор санаачилга гарган ажиллаж буй иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

## **Тав. НУТГИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО:**

### **5.1 Мэргэшсэн ёс зүйтэй төрийн алба:**

- 5.1.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдэд ойртуулан, түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх "Цахим Ерөө" хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.
- 5.1.2 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлт, саналыг хугацаа болоогүй нэрийдлээр удаашруулдаг хүнд суртлыг цахимаар хянаж дүгнэдэг болно.
- 5.1.3 "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн дагуу Бугант тосгоны бие даасан байдлыг хангаж, сум болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжилна.
- 5.1.4 Төр, төсвийн байгууллагын шинэ залуу боловсон хүчний нийгмийн асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 5.1.5 Сумандаа Онцгой байдлын хэсэгтэй болох асуудлыг холбогдох шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 5.1.6 "Тэргүүний өрхийн аж ахуй", "Бүтээлч айл өрх", "Соёлч өрх"-ийг жил бүр шалгаруулан туршлагыг түгээн дэлгэрүүлж, бусад аймаг, сум, нийслэл, дүүргийн туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.



## 5.2 Иргэнд ээлтэй төр:

- 5.2.1 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 5.2.2 Сумын хэмжээний төр, төсвийн байгууллагууд, үйлчилгээний газруудад тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дараалал харгалзахгүйгээр үйлчлэх үйлчилгээний соёлыг хэвшүүлнэ.
- 5.2.3 Шинэ залуу гэр бүл, зорилтот бүлгийн иргэд, төр, төсвийн байгууллагын ажилтнуудыг орон сууцжуулах бодлогыг аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2.4 Сумын хэмжээнд байгаа мэргэжилтэй боловсон хүчнийг бодлогоор дэмжиж ажилтай, орлоготой болгохын зэрэгцээ ажилгүйдлийг багасган, өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжиж ажиллана.
- 5.2.5 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, зорилтот бүлгийн өрхүүдийг малжуулах, туслах аж ахуй эрхлэх зэрэг төсөл, хөтөлбөрт хамруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.



**ЕРӨӨ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**